

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/16/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: [khurelbataart@audit.gov.mn](mailto:khurelbataart@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.15 № 4/28  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 12,654, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 13,541, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1,168 үйлчилгээ тус тус үзүүлж 16,699 тоон гарын үсэг иргэнд олгож, 2,652 улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, 16,465 архивын лавлагаа, мэдээлэл, хуулбар олгож, давхардсан тоогоор 63,170 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,766,987.66	36,288,399.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	400,200.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	400,200.00	-
3121	Төгрөг	400,200.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	400,200.00	-
33	АВЛАГА	19,835,200.00	34,423.58
335	Бусад авлага	19,835,200.00	34,423.58
3351	Байгууллагаас авах авлага	19,835,200.00	34,423.58
35	БАРАА МАТЕРИАЛ	33,531,587.66	36,253,975.76
351	Түүхий эд материал	12,027,047.66	13,025,875.76
35110	Тусгай зориулалттай материал	12,027,047.66	13,025,875.76
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,339,875.00	4,554,315.00
354	Хангамжийн материал	17,164,665.00	18,673,785.00
35410	Бичиг хэргийн материал	1,615,940.00	2,019,150.00
35420	Аж ахуйн материал	7,923,450.00	8,594,360.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,086,000.00	1,086,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,539,275.00	6,974,275.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	913,800,398.27	860,138,371.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	913,800,398.27	860,138,371.97
392	Биет хөрөнгө	901,350,398.27	847,688,371.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	688,700,983.00	688,700,983.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,435,049.04)	(43,043,811.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	129,040,563.00	71,040,563.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(117,613,520.96)	(62,827,376.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	348,648,189.97	359,656,737.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,005,079.33)	(188,209,948.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,927,655.92	90,024,775.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(51,142,511.32)	(67,695,218.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,500,000.00	2,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,270,832.97)	(2,458,332.94)
393	Биет бус хөрөнгө	12,450,000.00	12,450,000.00
39301	Програм хангамж	550,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	12,450,000.00	12,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	967,567,385.93	896,426,771.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	400,200.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	400,200.00	-
414	Урьдчилж орсон орлого	400,200.00	-
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	400,200.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	967,167,185.93	896,426,771.31
51	Засгийн газрын хувь оролцоо	967,167,185.93	896,426,771.31

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,213,991.97	190,213,991.97
51101	Өмч: - төрийн	177,763,991.97	177,763,991.97
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	12,450,000.00	12,450,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	776,953,193.96	706,212,779.34
51210	Өмнөх үеийн үр дүн	776,953,193.96	776,953,193.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	(70,740,414.62)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	967,567,385.93	896,426,771.31

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	752,137,186.98	1,194,585,084.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,078,086.98	45,473,053.40
120	Нийтлэг татварын бус орлого	59,078,086.98	45,473,053.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,990,000.00	10,160,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,990,000.00	10,160,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		11,829,283.40
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	51,088,086.98	23,483,770.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,059,100.00	1,149,112,031.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	688,061,100.00	1,084,216,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,061,100.00	1,084,216,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,998,000.00	64,896,031.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,000.00	56,706,031.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,698,000.00	8,190,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	800,558,050.44	1,246,110,149.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	800,558,050.44	1,246,110,149.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,226,070.60	1,243,571,700.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,539,309.84	945,113,476.19
210101	Үндсэн цалин	430,146,255.10	596,662,868.78
210102	Нэмэгдэл	80,972,537.74	256,766,207.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,684,200.00	71,096,000.00
210104	Урамшуулал	5,736,317.00	20,588,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,022,247.32	118,893,947.33
210201	Тэтгэврийн даатгал	46,231,372.53	81,201,822.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,426,872.13	9,542,902.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,314,617.74	7,634,321.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,489.82	1,864,989.24
210205	Эрүүл мэндийн даатгал	10,044,895.10	18,649,910.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,722,509.00	41,416,406.05
210301	Гэрэл, цахилгаан	1,952,786.00	2,690,874.05
210302	Түлш, халаалт	32,586,297.00	36,771,338.00

210303	Цэвэр, бохир ус	3,183,426.00	1,954,194.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,002,670.50	18,799,379.00
210401	Бичиг хэрэг	13,228,130.00	11,964,610.00
210402	Тээвэр, шатахуун	3,750,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,051,650.00	2,505,084.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,623,450.00	2,829,685.00
210408	Бараа материал акталсны зардал	7,068,940.50	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	552,000.00	5,531,210.00
210604	Урсгал засвар	552,000.00	5,531,210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,299,240.40	26,866,421.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,194,494.00	1,933,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	235,400.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	74,250.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,000,000.00
210807	Газрын төлбөр	37,350.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,656,946.40	20,933,421.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,088,093.54	86,950,859.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,698,000.00	8,190,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	880,000.00	750,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,510,093.54	78,010,859.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,331,979.84	2,538,448.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,065,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,065,000.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,266,979.84	1,038,448.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,266,979.84	1,038,364.95
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	83.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(48,420,863.46)	(51,525,064.63)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,987,220.00	19,215,349.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	77,220.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,910,000.00	19,215,349.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,987,220.00)	(19,215,349.99)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(57,408,083.46)	(70,740,414.62)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	960,639,618.69	1,433,731,602.62
11	ТАТВАРЫН ОРЛОГО	267,580,518.69	19,050,859.67
118	Бусад татвар, төлбөр, хураамж	267,580,518.69	19,050,859.67
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	267,580,518.69	19,050,859.67
118001	Улсын тэмдэгтийн хураамж	267,580,518.69	284,619,571.62

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,059,100.00	1,149,112,031.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	688,061,100.00	1,084,216,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,061,100.00	1,084,216,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,998,000.00	64,896,031.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,000.00	56,706,031.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,698,000.00	8,190,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	960,241,418.69	1,432,392,102.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,241,418.69	1,432,392,102.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,727,120.16	1,144,833,882.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,539,309.84	945,151,904.00
210101	Үндсэн цалин	430,146,255.10	594,324,939.08
210102	Нэмэгдэл	80,972,537.74	259,234,822.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,684,200.00	71,003,742.50
210104	Урамшуулал	5,736,317.00	20,588,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ШИМТГЭЛ	67,022,247.32	118,889,943.10
210201	Тэтгэврийн даатгал	46,231,372.53	81,535,529.98
210202	Тэтгэмжийн даатгал	5,426,872.13	9,429,465.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,314,617.74	7,543,611.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,489.82	1,852,747.67
210205	Эрүүл мэндийн даатгал	10,044,895.10	18,528,588.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,722,509.00	41,416,406.05
210301	Гэрэл, цахилгаан	1,952,786.00	2,690,874.05
210302	Түлш, халаалт	32,586,297.00	36,771,338.00
210303	Цэвэр, бохир ус	3,183,426.00	1,954,194.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,645,060.00	17,916,489.00
210401	Бичиг хэрэг	10,731,600.00	12,171,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,750,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,051,650.00	2,505,084.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,831,310.00	1,739,705.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,577,700.00	6,586,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,190,500.00	738,980.00
210602	Тавилга	19,835,200.00	-
210604	Урсгал засвар	552,000.00	5,847,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,642,294.00	5,933,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,194,494.00	1,933,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	235,400.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	74,250.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	-

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,000,000.00
210807	Газрын төлбөр	37,350.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,578,000.00	8,940,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,698,000.00	8,190,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	880,000.00	750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	277,514,298.53	287,558,220.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,065,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,065,000.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	244,254,119.69	266,969,660.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,266,979.84	3,393,213.64
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	83.90
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	234,987,139.85	263,576,363.26
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,195,178.84	19,088,559.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,195,178.84	19,088,559.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	398,200.00	1,339,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,739,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,739,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,739,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,739,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,000.00	400,200.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	400,200.00	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	177,763,991.97	-	(51,748,831.37)	126,015,160.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	177,763,991.97	-	(51,748,831.37)	126,015,160.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	12,450,000.00	-	366,421,460.49	378,871,460.49
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	-	776,953,193.96	967,167,185.93
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	190,213,991.97	-	776,953,193.96	967,167,185.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,213,991.97	-	776,953,193.96	967,167,185.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(70,740,414.62)	(70,740,414.62)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	-	706,212,779.34	896,426,771.31

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	400,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,084,216,000.00	1,083,177,635.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,084,216,000.00	1,083,177,635.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,082,716,000.00	1,081,677,635.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	897,413,300.00	897,413,300.00
210101	Үндсэн цалин	680,583,700.00	594,324,939.08
210102	Нэмэгдэл	181,855,700.00	211,496,218.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,973,900.00	71,003,742.50
210104	Урамшуулал	1,000,000.00	20,588,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,922,600.00	112,922,600.00
210201	Тэтгэврийн даатгал	77,050,100.00	77,477,687.25
210202	Тэтгэмжийн даатгал	8,968,100.00	8,952,078.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,174,500.00	7,161,702.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,793,600.00	1,757,320.34
210205	Эрүүл мэндийн даатгал	17,936,300.00	17,573,811.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,418,100.00	41,416,406.05
210301	Гэрэл, цахилгаан	2,027,800.00	2,690,874.05
210302	Түлш, халаалт	36,771,500.00	36,771,338.00
210303	Цэвэр, бохир ус	2,618,800.00	1,954,194.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,146,000.00	17,916,489.00
210401	Бичиг хэрэг	12,840,000.00	12,171,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,750,000.00	2,505,084.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,056,000.00	1,739,705.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,406,000.00	5,325,840.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,496,000.00	2,478,680.00
210604	Урсгал засвар	2,910,000.00	2,847,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,660,000.00	5,933,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,940,000.00	1,933,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	4,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	750,000.00	750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,084,216,000.00	1,083,177,635.05
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,084,216,000.00	1,083,177,635.05
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	45.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45	45
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	40	40
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,998,000.00	64,896,031.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,998,000.00	64,896,031.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,998,000.00	64,895,947.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		47,738,604.00
210102	Нэмэгдэл		47,738,604.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,967,343.10
210201	Тэтгэврийн даатгал		4,057,842.73
210202	Тэтгэмжийн даатгал		477,386.64
210203	ҮОМШӨ-ний даатгал		381,909.30
210204	Ажилгүйдлийн даатгал		95,427.33
210205	Эрүүл мэндийн даатгал		954,777.10
2104	Хангамж, бараа материалын зардал	300,000.00	
210401	Бичиг хэрэг	300,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,000,000.00
210604	Урсгал засвар		3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,698,000.00	8,190,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,698,000.00	8,190,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		83.90
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		83.90
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг		83.90
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,998,000.00	64,896,031.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,998,000.00	64,896,031.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,000.00	56,706,031.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,698,000.00	8,190,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, олон улсын жишигт нийцсэн улсын бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэхийн тулд улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд үндэслэн төрийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн ой санамжийг бүрдүүлэх, төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх, улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх чиг үүрэг бүхий Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 20 арга хэмжээтэй баталснаас нийт 85.69%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь захиргааны аж ахуйн нэгж, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг, иргэний бүртгэлийн тасаг гэсэн бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, улсын ахлах бүртгэгч 2, улсын бүртгэгч 37, үйлчилгээний ажилтан 5, гэрээтээр 3 бүгд 48 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Орон тооны бус дотоод хяналт шалгалтын хороог шинэчлэн байгуулах тухай" А/02 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод хяналт шалгалтын хороо нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 4 арга хэмжээг улирал, хагас, бүтэн жилээр төлөвлөн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, санхүү, бүртгэлийн болон өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар хийж хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын дотоод хяналтын хороо хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал, шилэн дансны хөтлөлт, архивын үйл ажиллагаа, цаг ашиглалт, аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжилтэд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулан ажилласан бөгөөд ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тусгасан болно.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг. Энэ онд шилэн данс, үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт болон аудитын албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2020 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн Хууль зүйн дотоод хэргийн сайдын А/87 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,140.6 мянган төгрөгөөр буюу 7,4 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	400.2	-	(400.2)
Авлага	19,835.2	34.4	(19,800.8)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	33,531.6	36,254.0	2,722.4
Үндсэн хөрөнгө	913,800.4	860,138.4	(53,662.0)
Нийт хөрөнгө	967,567.4	896,426.8	(71,140.6)
Өр төлбөр	400.2	-	(400.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	967,167.2	896,426.8	(70,740.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	967,567.4	896,426.8	(71,140.6)

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 999.0 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 214,440.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 403,210.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 11,009.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 14,097.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 67,073.0 мянган төгрөг, шилжүүлсэн 19,835.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 1,740.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 19,835.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 17,339.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 16,320.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 896,427.0 мянган төгрөг болж 70,740.0 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 822,257.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 74,405.0 мянган төгрөгөөр бууруулж 2023 оны урсгал зардлын төсвийг 747,852.9 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 747,852.9 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 1,084,216.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,084,216.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 1,038.3 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,083,177.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70406 /Улсын бүртгэл, мэдээлэл/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,082,716.0	1,081,677.6	1,038.3	99.9%
2	70406 /Улсын бүртгэл, мэдээлэл /80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,500.0	1,500.0	0.0	100.0%
	ДҮН	1,084,216.0	1,083,177.6	1,038.3	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 8,190.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас 56,706.0 мянган төгрөг, автомашины дуудлага худалдааны дэнчин 2,200.0 мянган төгрөг, нийт 67,096.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 53,705.9 мянган төгрөг, урсгал засварын зардалд 3,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 8,190.0 мянган төгрөг, автомашины дуудлага худалдааны дэнчин буцаахад 2,200.0 мянган төгрөг нийт 67,096.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70406	2023.01.01-2023.12.31	Улсын бүртгэл, мэдээлэл	Хөтөлбөр 85.69 %	1,084,216.0	1,083,177.6

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь батлагдсан төсвийг бүрэн зарцуулж хөтөлбөрийн хэрэгжүүлэн, үнэлгээгээрээ 3-р байрт шалгарч ажилласан байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 40,529.1 мянган төгрөгийн цахилгаан дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар, 19,162.0 мянган төгрөгийн барааг шууд худалдан авалтаар авахаар, нийт 59,691.1 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 80,792.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь төсөв тодотгон нэмэгдсэнтэй холбоотой байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 752,137.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,282.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,461.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус хэлтэст тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 158 мэдээллийг хуулийн

хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 20 орлогын, 17 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 9 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 556 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	10,337.1	3	10,337.1	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>10,337.1</b>	<b>3</b>	<b>10,337.1</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 32,558.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 32,558.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний журналд 1,109.6 мянган төгрөгийн 14 ширхэг ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичиж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 19,088.6 мянган төгрөгийг зохих кодоор тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Автомашинь дуудлага худалдааны барьцаа дэнчин 2,200.0 мянган төгрөгийг орлого, зардал бууруулан бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан “Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Үр дүнгийн тайланд орлого болон үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийг Э-тайлантай зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар зөрчил<sup>2</sup> илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	4	32,558.2			4	32,558.2	4	32,558.2				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>32,558.2</b>			<b>4</b>	<b>32,558.2</b>	<b>4</b>	<b>32,558.2</b>				

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)